



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/270

Хэрлэн сум

Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн  
төлбөрийн хэлбэрээр орлуулан хаалгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, Улсын их хурлын 2009 оны 33 дугаар тогтоол, Засгийн газрын 2016 оны 215, 2023 оны 119 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүрч цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийг дараагийн ээлжит цэрэг татлагын өмнө барагдуулж дуусган цэргийн үүрэгтний үнэмлэхэд тэмдэглэл хийж, цэргийн бүртгэлд тусгаж ажиллахыг Цэргийн штабын дарга (хурандаа Н.Хүрэлээ)-д, Төлбөрийн орлогод хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ